

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА, САНГИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 05 сарын 13 -ны өдөр


Дугаар 145/124

Улаанбаатар хот

“Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах,
активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар /Б.Нямаа/, Санхүүгийн зохицуулах хорооны Бичил санхүүгийн зохицуулалтын газар /Н.Оюунчимэг/-г тус тус даалгасугай.



Санхүүгийн зохицуулах хорооны дарга,
Сангийн сайдын 2015 оны 05 дугаар сарын 13-ны
өдрийн 14/124 дугаар хамтарсан тушаалын хавсралт

УХА0410 5043239

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ АКТИВЫГ АНГИЛАХ, АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛЖ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) нь зээл, санхүүгийн түрээс, өмчлөх бусад хөрөнгө, авлагыг ангилах, тэдгээрт учирч болзошгүй алдагдлаас хамгаалах эрсдэлийн санг байгуулж, зарцуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2 ХЗХ-ны зээлд байгуулсан эрсдэлийн сангийн зардлыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12.1.15-д заасны дагуу албан татвар ногдох орлогоос хасч тооцох бөгөөд санхүүгийн түрээс, өмчлөх бусад хөрөнгө, авлагын ангилалд байгуулсан эрсдэлийн сангийн зардал нь албан татвар ногдох орлогоос хасч тооцох зардалд хамаарахгүй.

1.3 ХЗХ нь зээл, санхүүгийн түрээс, өмчлөх бусад хөрөнгө, авлагыг энэ журмын хавсралтад заасан хугацааны үзүүлэлтээр тооцон ангилж, эрсдэлийн санг байгуулна.

1.4 ХЗХ нь дотооддоо хийсэн активын эрсдэлийн үнэлгээ, дүгнэлт, тэдгээртэй холбогдох нотлох баримтад үндэслэн тухайн активын ангиллыг бууруулж болно.

1.5 Эрсдэлийн санг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

1.6 Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

1.6.1 “актив” гэж зээл, санхүүгийн түрээс, өмчлөх бусад хөрөнгө, авлага хэлбэрээр үүссэн хөрөнгийг,

1.6.2 “төлбөр хариуцагч” гэж активыг ХЗХ-нд төлж барагдуулах үүрэг хүлээсэн этгээдийг.

Хоёр. Активыг ангилах

2.1 ХЗХ нь активыг дор дурдсан байдлаар тухай бүр ангилна.

2.1.1 Хэвийн;

2.1.2 Хугацаа хэтэрсэн;

2.1.3 Чанаргүй, үүнээс:

2.1.3.1 хэвийн бус;

2.1.3.2 эргэлзээтэй;

2.1.3.3 муу.

2.2 Төлбөр хариуцагчийн төлбөрийн чадвар алдагдсан, дампуурсан үед барьцаанд тавьсан эд хөрөнгийн тухайн үеийн үнэлгээ нь активын үндсэн өр болон хүүгийн 75-аас доошгүй хувийг төлж барагдуулахад хангалттай тохиолдолд эргэлзээтэй ангилалд, хангалтгүй тохиолдолд муу ангилалд хугацаа харгалзалгүй ангилна.

2.3 Хууль хяналтын байгууллагаар гэмт хэргийн шинж чанартай үйлдлээс үүссэн байж болзошгүй шалтгаанаар шалгагдаж байгаа активт 100 хувь эрсдэлийн сан байгуулна.

2.4 Активын гэрээний хугацааг 1 (нэг) удаа сунгасан бол ангиллыг хэвээр хадгална, харин 2 болон түүнээс дээш сунгасан бол өмнөх ангиллаас нэг шатлалаар бууруулна.

2.5 Төлбөр хариуцагчийн санхүүгийн чадвар муудсан болон анхны гэрээ, хэлцлийн дагуу төлбөр хийх чадваргүй болсноос шалтгаалан актив төлөгдөх хугацааг сунгасан, ХЗХ-ноос төлбөрийг нь төлүүлэхээр хууль хяналтын байгууллагад нэхэмжлэл гаргасан байгаа активт энэ журмын 2.4 дэх хэсэг хамаарахгүй.

2.6 ХЗХ нь Монголбанкны Зээлийн мэдээллийн санд ирүүлэх зээлдэгчийн талаарх мэдээлэлдээ тухайн активын ангилал, түүний өөрчлөлтийг журмын дагуу үнэн зөв тусгасан байна.

Гурав. Активын эрсдэлийн санг байгуулах, зарцуулах

3.1 ХЗХ активын эрсдэлийн санг энэ журмын 3.2-т заасан хувь хэмжээгээр зардлаар байгуулна.

3.2 Активын ангилалд эрсдэлийн санг актив тус бүрийн үлдэгдэл дүнгээс дор заасан хувь хэмжээгээр байгуулна. Үүнд:

3.2.1 Хэвийн ангилалд 0 хувь;

3.2.2 Хугацаа хэтэрсэн ангилалд 5 хувь;

3.2.3 Чанаргүй ангилалтай актив, үүнээс:

3.2.3.1 хэвийн бус ангилалд 25 хувь;

3.2.3.2 эргэлзээтэй ангилалд 50 хувь;

3.2.3.3 муу ангилалд 100 хувь.

3.3 Активын эрсдэлийн санг тухайн сарын сүүлийн өдрөөр байгуулах бөгөөд нийтээр

амрах баярын өдөр болон 7 хоног бүрийн амралтын өдөр таарвал, өмнөх ажлын өдөр санг байгуулна.

3.4 Активыг ангилж сан байгуулахдаа дараахь үндсэн зарчмыг баримтална. Үүнд:

3.4.1 Хэвийн активыг санхүүгийн тайлан тэнцэлд анх тусгах үед эрсдэлийн санг байгуулахгүй. Харин активтай холбоотой гэрээ, хэлцлийн дагуу үүрэг хүлээсэн этгээд нь үндсэн өр болон хүүгийн төлбөрийг бүхэлд нь болон хэсэгчлэн буцаан төлөх чадваргүй болж болзошгүй нь үндэслэл бүхий баримтаар нотлогдсон бол ХЗХ нь хүлээж болзошгүй алдагдлын дүнг тухай бүр тооцож, холбогдох эрсдэлийн санг журмын 3.3-д заасан хугацаанд зардлаар байгуулна.

3.4.2 ХЗХ эрсдэлийн сан байгуулах, зориулалтын дагуу ашиглах, эрсдэлийн сангаас зарцуулах гүйлгээг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу хийнэ.

3.4.3 Зээлийг өмчлөх бусад хөрөнгөд шилжүүлэхээс бусад тохиолдолд активын хэлбэрийг өөрчлөхдөө хэлбэр өөрчлөгдөхөөс өмнөх ангиллыг хэвээр хадгалж, түүнд үндэслэн энэхүү журмын дагуу дараагийн ангиллыг хийнэ.

3.5 ХЗХ нь дутуу байгуулсан эрсдэлийн санг нэмж байгуулах тохиолдолд зардлаар нэмж байгуулах, илүү байгуулсан эрсдэлийн санг буцаах тохиолдолд орлогын зээлийн эрсдэлийн зардлын нөхөлт дансанд хаана.

3.6 ХЗХ активыг холбогдох сангаас зөвхөн дор дурьдсан нөхцөлд дараахь баримт бичгийг үндэслэн хорогдуулж болно:

3.6.1 Төлүүлэх тухай шүүхийн шийдвэр гарснаас хойш хагас жилийн дотор төлбөр хариуцагчаас төлбөрийг бүрэн хийгээгүй нөхцөлд ХЗХ-ны Тэргүүлэгчдийн зөвлөлийн шийдвэрээр;

3.6.2 Төлбөр хариуцагчаас тодорхой хэсгийг гаргуулахаар шүүхийн шийдвэр гарсан боловч үлдэх хэсгийг төлбөр хариуцагч хариуцахгүй болсныг тогтоосон шүүхийн шийдвэрээр тухайн үлдэх хэсгийг;

3.6.3 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн тухай шүүгчийн захирамж болон ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор;

3.6.4 Төлбөр хариуцагчийн талаар шүүхэд хандсан боловч тодорхой шийдвэр гаргах боломжгүй нөхцөл бий болсон активыг муу ангилалд орсноос хойш хагас жилийн дараа Тэргүүлэгчдийн зөвлөлийн шийдвэрээр.

3.7 Активыг холбогдох эрсдэлийн сангаас хорогдуулсан тохиолдолд тэнцлийн гадуурх дансанд /хувийн хэрэг болон холбогдох бусад бичиг баримтын хамтаар/ нэрийн данс бүрээр дэлгэрэнгүй бүртгэж, төлүүлж барагдуулах арга хэмжээг эрчимтэй үргэлжлүүлнэ.

3.8 Сангаар хорогдуулж тэнцлийн гадуурх дансанд бүртгэсэн активын төлбөр хийгдсэн нөхцөлд тэр хэмжээгээр ХЗХ-ны үйл ажиллагааны бусад орлогод бүртгэнэ.

Дөрөв. Хяналт, хариуцлага

4.1 ХЗХ-ны удирдлага нь актив хөрөнгийн эрсдэлийг хянаж, удирдах зохистой механизмыг бүрдүүлж ажиллах үүрэгтэй.

4.2 Активын ангилал, активын эрсдэлийн сан, эрсдэлийн сангийн зарцуулалтад тухайн ХЗХ-ны Хяналтын зөвлөл хяналт тавьж, Тэргүүлэгчдийн зөвлөлдөө тайлагнана.

4.3 Санхүүгийн зохицуулах хороо нь тухайн ХЗХ-ны удирдлага активын эрсдэлийг хэрхэн үнэлж, дүгнэн ангилж, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах талаар авч байгаа арга хэмжээ нь зохистой эсэх, ангиллыг үнэн зөв хийж байгаа эсэх, эрсдэлийн санг бүрэн байгуулж байгаа байдлыг газар дээр нь шалгаж, зайнаас хяналт тавина.

4.4 Санхүүгийн зохицуулах хороо нь ХЗХ-ны үйл ажиллагаанд хийсэн газар дээрх шалгалтаар активыг энэ журмын дагуу ангилаагүй, холбогдох санг тогтоосон хувь хэмжээгээр байгуулаагүй, зориулалтын бусаар зарцуулсан нь нотлогдсон тохиолдолд буруутай этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

_____оОо_____

*"Хадгаламж, зээлийн хоршооны активыг
ангилах, активын эрсдэлийн сан байгуулж,
зарцуулах журам"-ын хавсралт*

Зээл, санхүүгийн түрээсийн хугацааны үзүүлэлтийг дүгнэх хүснэгт

<i>Ангилал</i>	<i>Хэвийн</i>	<i>Хугацаа хэтэрсэн</i>	<i>Хэвийн бус</i>	<i>Эргэлзээтэй</i>	<i>Муу</i>
Хугацааны үзүүлэлт	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт, хуваарьт заасан хугацаандаа хийгдэж байгаа.	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 90-хүртэл хоног хэтэрсэн.	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 91-180 хоног хэтэрсэн.	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 181-360 хоног хэтэрсэн.	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 361 -ээс дээш хоног хэтэрсэн.

Өмчлөх бусад хөрөнгийг хугацааны үзүүлэлтээр дүгнэх хүснэгт

<i>Ангилал</i>	<i>Хэвийн</i>	<i>Хугацаа хэтэрсэн</i>	<i>Хэвийн бус</i>	<i>Эргэлзээтэй</i>	<i>Муу</i>
Хугацааны үзүүлэлт	Өмчлөлд авснаас хойш 30 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 31-60 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 61-90 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 91-120 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 121 хоногоос дээш хугацаанд борлогдоогүй

Авлагыг хугацааны үзүүлэлтээр дүгнэх хүснэгт

<i>Ангилал</i>	<i>Хэвийн</i>	<i>Хугацаа хэтэрсэн</i>	<i>Хэвийн бус</i>	<i>Эргэлзээтэй</i>	<i>Муу</i>
Хугацааны үзүүлэлт	30 хүртэл хоногийн дотор байгаа	31-60 хоногийн дотор төлөгдөөгүй	61-90 хоногийн дотор төлөгдөөгүй	91-120 хоногийн дотор төлөгдөөгүй	121-ээс дээш хоногоор төлөгдөөгүй буюу ашиглан, гэмт хэргийн улмаас бий болсон авлага